



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20²⁰ он ⁰¹ дугаар
сарын ⁰² ны өдөр

Дугаар ... *128/04*

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

“Чингис”, “Самурай” бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0016629

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.БАТ-ЭРДЭНЭЭС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. “Чингис”, “Самурай” бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийн ажлын явц, үр ашиг, үр өгөөжийн талаар болон тус хоёр бондын болон бондын хүүгийн эргэн төлөлтийн талаар

Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банкны олон улсын зах зээл дээр 2012, 2013 онуудад арилжаалсан “Чингис”, “Самурай” бондын хөрөнгийг Хөгжлийн банкаар дамжуулан төсөл, хөтөлбөр санхүүжүүлсэн бөгөөд уг асуулгын хариуг Монгол Улсын Хөгжлийн банкнаас ирүүлсэн 2019 оны 2/1613 дугаар албан бичгээс үзнэ үү.

Асуулга 2. 2021-2024 онуудад эргэн төлөгдөх бондын эх үүсвэрийг бүрдүүлэхэд авч хэрэгжүүлж буй ажлын талаар

Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн баримт бичгийг боловсруулж, тухайн төсвийн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт гурван жилд нэг удаа Төсвийн тухай хуулийн 8.1-д заасан цаглабрын дагуу батлуулна” гэж заасныг үндэслэн Засгийн газрын 2019-2022 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг боловсруулан Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор батлуулсан. Уг стратегийн баримт бичигт Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах тухай зорилт дэвшүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар 2012 онд 1.5 тэрбум ам.долларын “Чингис”, 2016 онд 500.0 сая ам.долларын “Мазаалай” бондуудыг төсөл, хөтөлбөр болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан бол, 2017 онд 600.0 сая ам.долларын “Хуралдай”, 2018 онд 800.0 сая ам.долларын “Гэрэгэ” бондуудыг гадаад бондын дахин санхүүжилт хийх зорилгоор тус тус арилжаалсан. Засгийн газар 2017 оны 03 дугаар сард Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын төлбөрийг дахин санхүүжүүлэх зорилгоор “Хуралдай” бонд, 2017 оны 10 дугаар сард “Чингис”, “ДимСам” бондуудыг дахин санхүүжүүлэх зорилгоор “Гэрэгэ” бондыг тус тус арилжаалж өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

2021-2024 онд төлөх нийт 2.9 тэрбум ам.долларын гадаад үнэт цаасны төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах замаар төлөх өрийн оновчтой зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Иймд Сангийн яамны зүгээс Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт тусгаснаар дараах арга замыг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Төсвийн сахилга бат, санхүү мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах бодлогыг тууштай үргэлжлүүлэх замаар төсвийн алдагдал болон шинээр зээллэг үүсгэх хэрэгцээг бууруулна;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан өрийн багцын оновчтой бүтцийг бий болгох зохицуулалтын арга хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шуурхай, бие даан авч хэрэгжүүлнэ;

- Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийж, гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авна;
- Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасыг эргүүлэн худалдан авахад гарах зардал нь ирээдүйд худалдан авах тухайн үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр, бусад зардалд төлөх төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс бага байх нөхцөлд боломжит хэмжээгээр эргүүлэн худалдан авна;
- Дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаас гаргахаас татгалзаж, өрийн дахин санхүүжилтэд урт хугацаанд жигд төлөгдөх эх үүсвэр ашиглахыг эрмэлзэнэ;
- Засгийн газрын өрийн багц дахь хувьсах хүүтэй гадаад зээлийг зардал, эрсдэлийн судалгаагаар ашигтай нөхцөлд тогтмол хүүтэй зээлд шилжүүлнэ;
- Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханган хамтарч ажиллана.

Асуулга 3. Ам.доллороор гаргасан бондын хөрөнгөөр дотоодын төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхдээ төгрөгт шилжүүлэн олгосны улмаас ханшийн зөрүүнээс хүлээсэн алдагдлын тооцоо, түүнийг багасгах талаар хэрэгжүүлж буй ажил болон хариуцах эзний талаар

Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банкны олон улсын зах зээл дээр 2012, 2013 онуудад арилжаалсан “Чингис”, “Самурай” бондын хөрөнгийг Хөгжлийн банкаар дамжуулан төсөл, хөтөлбөр санхүүжүүлсэн бөгөөд уг асуулгын хариуг Монгол Улсын Хөгжлийн банкнаас ирүүлсэн 2019 оны 2/1613 дугаар албан бичгээс үзнэ үү.

Асуулга 4. “Чингис”, “Самурай” бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, бусад хариуцлагатай ажил, албан тушаал эрхэлж байсан, эсхүл одоо эрхэлж буй хүмүүсийн болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аж ахуйн нэгж хамрагдсан эсэх талаар

Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банкны олон улсын зах зээл дээр 2012, 2013 онуудад арилжаалсан “Чингис”, “Самурай” бондын хөрөнгийг Хөгжлийн банкаар дамжуулан төсөл, хөтөлбөр санхүүжүүлсэн бөгөөд уг асуулгын хариуг Монгол Улсын Хөгжлийн банкнаас ирүүлсэн 2019 оны 2/1613 дугаар албан бичгээс үзнэ үү.

----oO-----



**МОНГОЛ УЛСЫН
ХОГЖЛИЙН БАНК**

Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг
1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-19
Утас: +(976) 70130513
Факс: +(976) 70130602

**САНГИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.НАРАНЦОГТ ТАНАА**

2019.12.13 № 2/1613
танай 2019.12.06-ны № 8-3/8054-т

Хариу хүргүүлэх тухай

Танай 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 8-3/8054 тоот албан бичигтэй танилцан дараах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. “Чингис”, “Самурай” бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийн талаар;

А. “Чингис бонд”-ын талаар

Монгол Улсын Засгийн газар 2011 онд олон улсын зах зээл дээр 1.5 тэрбум ам.долларын “Чингис бонд”-ыг арилжаалж, 2013-2014 онд 1.2 тэрбум ам.доллартай тэнцэх 2.0 их наяд төгрөг болон 269.9 сая ам.долларын эх үүсвэрийг Хөгжлийн банктэй гэрээ байгуулж байршуулсан.

Тухайн үеийн Засгийн Газраас гаргасан холбогдох тогтоолуудын дагуу “Чингис бонд”-ын уг эх үүсвэрээс боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөр зам, авто зам, дэд бүтцийн чиглэлээр хэрэгжих бүтээн байгуулалтын нийт 306 төсөл, хөтөлбөрт Хөгжлийн банк санхүүжилт олгосон. Эдгээр төслүүдийн дийлэнх нь улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй байсан бөгөөд энэ нь жил бүрийн улсын төсөвт тусгахад хүндрэлтэй байсны улмаас эргэн төлөлт удааширч, улмаар Хөгжлийн банкны санхүүгийн үйл ажиллагаанд ноцтой хүндрэлийг бий болгож байлаа.

Улсын Их Хурлын 2016 оны “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах арга хэмжээний тухай” 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” 219 тогтоолын дагуу Хөгжлийн банкнаас олгогдсон төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй дээрх зээлүүдийг Засгийн газарт шилжүүлж, Сангийн яам болон Хөгжлийн банкны хооронд үүссэн “Чингис бонд”-д холбогдох өглөг авлагын тооцоог бүрэн хийж дуусгасан юм.

Хөгжлийн банк нь 2016 оны жилийн эцэст “Чингис бонд” болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлж, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон нийт 348¹ төсөл хөтөлбөрт хамаарах 3.1 их наяд төгрөгийн зээлийн багцыг Засгийн газарт шилжүүлсэн бөгөөд төсөл хөтөлбөрийг захиалагч төсвийн ерөнхийлөн захирагч, яамдад төсөлтэй холбоотой баримт бичгүүдийг шилжүүлж, хүлээлгэн өгсөн ба санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт цаашдын үр дүнг тухайн яамд хариуцан ажиллах болсон.

№	ЗАХИАЛАГЧ ТАЛ	Төсөл, арга хэмжээний тоо	2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх үлдэгдэл санхүүжилтийн дүн (сая төгрөг, мянган ам.доллар)		
			MNT	USD	Нийт (₮)
1	Зам, тээврийн хөгжлийн яам	88	767,909.0	371,125.2	1,691,836.2
2	Эрчим хүчний яам	50	278,573.4	172,340.9	707,621.3
3	Барилга, хот байгуулалтын яам	37	170,377.3	323.3	171,182.2
4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	3	3,783.3	4,135.6	14,079.0
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1	7,995.0	-	7,995.0
6	Боловсрол, соёл, шинэжлэх ухаан, спортын яам	1	2,000.0	-	2,000.0
7	Шадар сайд	1	19,966.3	-	19,966.3
8	Нийслэлийн засаг даргын тамгын газар	165	205,865.1	58,196.8	350,747.9
8.1	Нийслэлийн авто замын газар	45	19,882.3	53,803.0	153,826.4
8.2	Гудамж тослийн нэгж	95	128,680.8	4,393.9	139,619.5
8.3	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар	25	57,302.0	-	57,302.0
9	Төрийн банк (6%)	1	-	58,392.8	145,370.7
10	Эрдэнэс Оюу толгой ХХК	1	-	2,512.0	6,253.7
	НИЙТ ДҮН	348	1,456,469.4	667,026.7	3,117,052.2

Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 42-р тогтоолын дагуу анх “Чингис бонд”-ын эх үүсвэрээр санхүүжүүлсэн Эгийн голын усан цахилгаан станц, Тавантолгойн цахилгаан станц болон Эрдэнэс Монгол ХХК-ийн Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын төслүүдэд хамаарах зээлийг Хөгжлийн банкинд үлдээж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн ба одоогоор цахилгаан станцуудад хамаарах бодлогын шийдвэр, хөрөнгө оруулалтын асуудлууд шийдвэрлэгдээгүй байгаагаас хүлээлтийн байдалтай, харин Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын ашиглалт хэвийн үргэлжилж байна.

¹ Үүнд 2016.12.31-ний өдрийн байдлаар зөвхөн санхүүжилтийн үлдэгдэлтэй байгаа төслүүд багтсан болно. Өөрөөр хэлбэл улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжилт нь олгогдоод төлөгдсөн эсвэл захиалагчийн хүсэлтээр цуцлагдсан төслүүд тусгагдаагүй болно. Мөн гэрээ байгуулсан боловч санхүүжилт олгогдож эхлээгүй төслүүд багтаагүй болно.

Б. “Самурай бонд”-ын талаар

Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 417 дугаар тогтоолоор 30 тэрбум иений үнэт цаасыг 10 жил хүртэлх хугацаатай, хаалттай хэлбэрээр Япон улсын зах зээл дээр Японы Олон Улсын хамтын ажиллагааны банк (ЯОУХАБ)-ны баталгаатайгаар арилжаалахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсөн.

“Самурай бонд”-ын эх үүсвэр болох 30.0 тэрбум иенээс холбогдох зардал, шинтгэлүүд болох 5.75 тэрбум иений төлбөр хасагдсан дүнгээр 24.3 тэрбум иен 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр Хөгжлийн банкны Монголбанк дахь харилцах дансанд шилжин орж ирсэн. “Самурай бонд”-ын төлбөрийг Хөгжлийн банкнаас гүйцэтгэж байгаа ба 2019 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 2.5 тэрбум иений хүүгийн төлбөрийг төлсөн, хуваарийн дагуу 2023 оны эцэст үндсэн төлбөр хийгдэхээр хүлээгдэж байна.

Тус эх үүсвэрээр дараах хүснэгтэд үзүүлсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэн.

№	Төсөл/арга хэмжээ	Эхлэх	Дуусах	Валют	Санхүүжилт	Эргэн төлөгдөх нөхцөл
1	“ТОСК” ТӨҮГ - Шинэ Яармаг Орон Суушны Хороолол	2015.05.28	2024.01.12	ам.доллар	38,704,763.2	Төслийн орлогоос
2	“Эрэл” ХХК - Байшин Үйлдвэрлэх Комбинат - 1 Төсөл	2013.08.19	2021.08.19	ам.доллар	14,000,000.0	Төслийн орлогоос
3	“Хотол” ХХК - Хотолын Цементгийн Үйлдвэрийг Өргөтгөх Төсөл	2012.10.19	2020.10.19	ам.доллар	61,265,000.0	Төслийн орлогоос
4	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	2012.07.17	2018.01.17	төгрөг	16,373,243,223.2	Төслийн орлогоос
5	6%-ын орон сууцны зээлийн санхүүжилт	2013.12.31	2017.02.15	ам.доллар	36,853,794.9	Улсын төсвөөс (хиагдсан)
6	6%-ын орон сууцны зээлийн санхүүжилт	2013.10.2	2017.02.15	ам.доллар	21,539,035.9	Улсын төсвөөс (хиагдсан)

Эдгээр төслүүдээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй “6 хувийн орон сууцны зээлийн санхүүжилт”-ийг УИХ-ын “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 81 дүгээр тогтоолын хүрээнд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон Сангийн яамтай тооцоон нийлж, хаасан.

“Самурай бонд”-ын эх үүсвэрээс санхүүжиж, арилжааны банкуудаар дамжуулан олгосон Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хамаарах зээлүүд эргэн төлөгдөж дууссан.

Харин, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй “Эрэл” ХХК, “Хөтөл” ХХК, “ТОСК” ТӨҮГ-т хамаарах зээлүүдийн эргэн төлөлтөд 2019 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар зарим хүндрэлүүд үүсээд байгаа хэдий ч зээлийн гэрээний дагуу асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

2. 2021-2024 онуудад эргэн төлөгдөх бондын эх үүсвэрийг бүрдүүлэхэд авч хэрэгжүүлж буй ажлын талаар;

Хөгжлийн банкнаас олон улсын хөрөнгийн зах зээлд арилжаалсан ам.долларын болон ненийн бондыг хуваарийн дагуу 2023 онд эргэн төлнө. Үүний тулд тухайн үеийн гадаад болон дотоод эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын хөрөнгө санхүүгийн зах зээлийн төлөв байдал зэргийг харгалзан үзэж эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус банкны дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө, жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

3. Ам.доллороор гаргасан бондын хөрөнгөөр дотоодын төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхдээ төгрөгт шилжүүлэн олгосны улмаас ханшийн зорүүнээс хүлээсэн алдагдлын тооцоо, түүнийг багасгах талаа хэрэгжүүлж буй ажил болон хариуцах эзний талаар;

Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам (хуучнаар) болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд 2013 оны 04 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”-нд заасны дагуу “Чингис бонд”-ын хөрөнгөөс хүлээн авсан эх үүсвэрээс холбогдох зээлийн олголтыг валютаар гүйцэтгэсэн тул тухайн эх үүсвэрээс аливаа ханшийн эрсдэл хүлээгээгүй болно.

Хөгжлийн банк нь өөрийн татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголбанк болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай санхүүгийн үүсмэл хэрэгслүүд ашиглан ам.доллар-төгрөг, ам.доллар-ненийн своп, форвард хэлцлүүдийг байгуулан ажиллаж байна.

4. “Чингис”, “Самурай” бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, бусад хариуцлагатай ажил, албан тушаал эрхэлж байсан, эсхүл одоо эрхэлж буй хүмүүсийн болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аж ахуй нэгж хамрагдсан эсэх талаар.

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан ба энэхүү шинэчилсэн найруулгаар Хөгжлийн банк нь зээл санхүүжилтийн шийдвэрээ хараат бусаар бие даан шийдвэрлэх эрх зүйн орчин нөхцөл бүрдсэн. Шинэчлэгдсэн хуулийн хүрээнд банкны зээл, санхүүжилтийн бодлого, дүрэм журмуудад томоохон өөрчлөлтүүдийг оруулж, шалгуур шаардлагуудыг өндөрсгөсөн.

Харин үүнээс өмнөх буюу 2012-2016 онуудад хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг Засгийн газраас шийдвэрлэж, холбогдох тогтоол гаргасны дагуу Хөгжлийн банкнаас санхүүжилтийг олгох зарчим үйлчилж байсан. Тухайн үед банкнаас тавигдах шалгуур шаардлагад тухайн зээлдэгч, төсөл хэрэгжүүлэгчийг хариуцлагатай албан тушаал эрхэлж байгаа этгээдтэй харилцаа, хамааралтай эсэхийг тогтоох чиглэлээр тусгасан зүйл байгаагүй тул энэ талаар аливаа судалгаа, бүртгэл хийгдээгүй байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Г.АМГАРТҮВШИН